

УВС АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. Ерөнхий мэдээлэл

Удирдлага, зохион байгуулалтын талаар:

МХЕГ-аас 2021 онд удирдах 1 ажилтан, төрийн захиргааны 37 албан хаагч, төрийн үйлчилгээний 20 албан хаагч, нийт 58 орон тоо батлагдсан бөгөөд одоогийн байдлаар 55 албан хаагч ажиллаж, 3 орон тоо сул байна.

2021 онд Газрын даргын нийт 80 тушаал гарснаас ажилд томилж, чөлөөлсөн 26, дотоод зохион байгуулалттай холбоотой 54 тушаал гаргаж хэрэгжилтийг ханган ажилласан.

Орчны эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч, Хилийн Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч зэрэг 3 ажилтан жирэмсний болон амаржсаны амралттай байх хугацаанд ТАТХ-ийн 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь хэсэгт зааснаар чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлсэн. Хилийн ариутгагч 1, лабораторийн 2 шинжээчийн жирэмсний болон амаржсаны амралттай байх хугацаанд түр ажиллах албан хаагчийг гаднаас авч түр томилох шийдвэрийг гаргаж сул орон тоог тухай бүр нөхөж хүний нөөцийн үйл ажиллагаа тасралтгүй, хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлсэн.

Харилцаа холбооны хяналтын улсын байцаагч, Хүнсний чанар стандартын хяналтын улсын байцаагч, Эрчим хүчний хяналтын улсын байцаагчийн сул орон тоонд Төрийн албаны зөвлөлөөс 3 иргэнийг нэр дэвшүүлэн ирүүлснийг Авлигатай тэмцэх газарт урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар хүргүүлээд байна.

Мэргэжлийн хяналтын газрын албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар 15 заалт бүхий ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж 87% биелэлттэй, албан хаагчдыг мэргэшүүлэх талаар 8 заалт бүхий ажлын төлөвлөгөө баталж, дотоодод зохион байгуулах сургалтын төлөвлөгөө, монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан.

Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах зорилгоор албан хаагчдаас санал авч нэгтгэх ажлыг зохион байгуулж, гарсан саналыг нийт албан хаагчдын хурлаар хэлэлцүүлэн, Газрын даргын 2021 оны А/08 дугаар тушаалаар уг журмын 19 заалтад нэмэлт өөрчлөлт оруулсан.

Төрийн албан хаагчийн хүний нөөцийн мэдээллийн систем HRMS программд байгууллагын албан хаагчдын мэдээллийг шинэчлэн оруулж, санхүүгийн программтай холбон цалинг бодож олгох ажлыг хийж хэвшүүлээ.

Төсвийн гүйцэтгэл:

2021 онд батлагдсан 1,099,877.3 мянган төгрөгийн төсвийг тухайн сарын хуваарийн хүрээнд холбогдох хууль дүрмийн дагуу зардлын зүйл ангилалаар нь хувиарлан зардлыг санхүүжүүлэн ажиллалаа. Мэргэжлийн хяналтын газрын албан хаагчдын цалинд 705,882.8 мянган төгрөгийг тухайн сар бүрт нь тооцон олгож,

95,294.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн. Мөн ахмад настанд хүндэтгэл үзүүлэх журмын дагуу сар шинийн баяр, ахмадын өдөр тохиолдуулан байгууллагын өндөр настангуудад 1,440.0 мянган төгрөг, албан хаагчидад тусламж дэмжлэгт 1,000.0 мянган төгрөгийн зарцуулсан. Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны төсвийн төсөлд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан орон тоогоор цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 999,607.9 мянган төгрөгийг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 134,947.1 мянган төгрөгийг, тогтмол зардалд 81,251.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1,560,418.2 мянган төгрөгийг, татаас урсгал шилжүүлэгт 12,864.0 мянган төгрөгийг нийт 2,789,089.0 мянган төгрөгийг төсөвлөж, 2023-2024 оны төсвийн төсөөлөл тооцоолон хүргүүлсэн. Мэргэжлийн хяналтын газрын эргэлтийн хөрөнгийн дансанд нийт 60,524.6 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авч, 35,146.2 мянган төгрөгийн зарлага гарган ажилласан

Хөрөнгө оруулалт:

МХЕГ-аас 14,424.8 мянган төгрөгийн өртөг бүхий хангамжийн материал хүлээн авсан. Үүнд: 321.6 мянган төгрөгийн гэрчилгээ, хэвлэмэл маягтууд, Covid19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зориулалтаар 14,103.2 мянган төгрөгийн багаж техник, хамгаалах хувцас хэрэгсэл тус тус хүлээн авч данс бүртгэлд тусган ажилласан. 2,500.0 мянган төгрөгийн эд хогшил орлогоор хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгасан. Дэлхийн байгаль хамгаалах сангаас шалгалтын зардал, сургалт сурталчилгааны эх бэлтгэх хэвлүүлэх ажилд зориулан 4,500.0 мянган төгрөг олгосон байна.

Хоёр. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Увс аймгийн МХГ-аас 2021 онд нийт 13 зорилтын хүрээнд 97 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласнаас биелэлт дунджаар 95.9 хувь байна.

Төлөвлөсөн арга хэмжээний нийт тоо	Биелэлтийн хувь						Биелэлтийн дундаж хувь
	100%	70%	50%	30%	10%	0%	
97	88	4	4	1			95.9%
Биелэлт хангалтгүй байгаа шалтгаан: Улсын байцаагчид 1-2-р улиралд коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажилд дайчлагдан ажилласан болон бэлэн байдлын дэглэмээс шалтгаалан зарим арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа хийгдэх боломжгүй байсан.							

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үр дүнгийн талаарх дүгнэлт:

1. Улсын байцаагчид 1-2-р улиралд коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажилд дайчлагдан ажиллаж эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байсан боловч 3-4 улиралд хяналт шалгалтын ажлыг сайтар зохион байгуулсаны үр дүнд төлөвлөгөөний биелэлтийн хувийг дээшлүүлж ажилласан.

2. Боршоо боомтоор орох урсгал хөдөлгөөнд эрүүл ахуй халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн ажилласны үр дүнд коронавирусын халдвар зөөвөрлөгдсөн тохиолдол гараагүй болно.

3. Боршоо боомт дээр явуулын лабораторийг ажиллуулж импортоор орж ирсэн хүнсний бүтээгдэхүүнийг лабораторийн шинжилгээнд хамруулж хэвшүүлсэнээр импортын хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын баталгаажилтыг сайжруулсан.

4. Хяналтын 23 чиглэлээр 88 хяналтын хуудсаар 511 шалгалт хийж 6483 зөрчлийг илрүүлж, үүний 31%-ийг арилгуулж ажилласан. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг бүрэн хийж зөрчил арилгахад цаг хугацааны хувьд боломжгүй байв.

5. Эрсдэлийн ангиллын жагсаалтаас их, дунд үнэлэгдсэн 504 объектод төлөвлөгөөт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхэд 310 объект буюу 61.5% эрсдэлийн түвшин буурч бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Мөн төлөвлөгөөт шалгалтын эрсдэл үүсэх магадлалын дундаж хувь 29.8%, гүйцэтгэлээр 24.4% болж эрсдэлийн түвшин буурсан.

Гурав. Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилт

Хяналт шалгалтын чиглэлээр 2021 онд 25 зорилтын хүрээнд нийт 160 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс биелэлт дунджаар 90 хувь байна.

Төлөвлөсөн арга хэмжээний нийт тоо	Биелэлтийн хувь						Биелэлтийн дундаж хувь
	100%	70%	50%	30%	10%	0%	
160	143	-	-	1		16	90.0%

Биелэлт хангалтгүй байгаа шалтгаан:
Улсын байцаагчид 1-2-р улиралд коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажилд дайчлагдан ажилласан болон бэлэн байдлын дэглэмээс шалтгаалан зарим арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа хийгдэх боломжгүй байлаа.
Мөн МХГ-ын 2022 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг батлуулах хугацаа болоогүй, Эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалтыг батлуулах хугацаа болоогүй, удирдамж ирээгүй, хамтран ажиллах байгууллага үйл ажиллагаа явуулаагүй, чиглэл өөрчлөгдсөн зэрэг шалтгааны улмаас зарим хяналт шалгалт тасалдсан.

Хяналт шалгалтын гүйцэтгэлийн үзүүлэлт:

№	Хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо:	2021 оны		Гүйцэтгэлийн хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
	Төлөвлөгөөт шалгалт	407	364	98%
	Төлөвлөгөөт бус шалгалт	18	18	100%
	- Иргэдийн өргөдөл гомдлоор	10	10	100%
	- МХЕГ-ын шийдвэрээр	3	3	100%
	- Засаг дарга, ИТХ-ын шийдвэрээр	5	5	100%
	Урьдчилан сэргийлэх шалгалт	35	35	100%
	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн	157	140	99.6%
	Нийт объектын тоо	611	551	98.6

Дүгнэлт:
Зарлагдсан 407 шалгалтаас 26 объектын үйл ажиллагаа зогссон тул 36 шалгалт хийгдээгүй, бусад

шалтгаанаар 7 шалгалт хийгээгүй, 244 объектод 364 хяналт шалгалт хийж төлөвлөгөөг 98%-тай, Зөвлөн туслах үйлчилгээ 157 үзүүлэхээс 13 объект үйл ажиллагаа зогссон тул 16 ЗТҮ хийгдээгүй, бусад шалтгаанаар 1 шалгалт хийгээгүй, 122 объектод 140 зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж төлөвлөгөөг 99.4% хэрэгжүүлсэн.

Нийт 39 объектын үйл ажиллагаа зогссон тул 52 шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ хийгдээгүй. Ковидын тархалт, өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэмээс шалтгаалан 8 хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ хийгдээгүй.

35 асуудлаар 425 объектод төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн.

Ирсэн өргөдөл гомдол, дээд газрын шийдвэрээр 18 төлөвлөгөөт бус шалгалт хийж асуудлыг бүрэн шийдвэрлэж ажилласан.

Улсын байцаагчийн авсан арга хэмжээ:	Тогтоосон	Биелэлт хангагдсан	Биелэлтийн хувь
• Дүгнэлт	126	126	100%
• Акт	15	15	100%
• Албан шаардлага	183	67	36.6%
• Зөвлөмж	127	53	41.7%
• Нөхөн төлбөр /мян.төг/	9,927.8	9,335.8	94%
○ Тогтоосон			
○ Барагдуулсан			
• Торгууль шийтгэвэр /мян.төг/	15.195.000	12.645.000	83.2%
○ Ногдуулсан			
○ Барагдуулсан			
Улсын орлого болгосон /мян.төг/	80.0	80.0	100%
Хурааж устгасан /мян.төг/	907.8	907.8	100%
Үйл ажиллагааг нь зогсоосон объектын тоо	2	2	100%

Дүгнэлт: 12 хяналтын чиглэлээр ажлын байрны дүгнэлт, техникийн дүгнэлт, урьдчилсан хяналтын дүгнэлт зэрэг нийт 126 дүгнэлт, 6 хяналтын чиглэлээр хураасан, үйл ажиллагаа зогсоосон, нөхөн төлбөр тогтоосон зөрөг 9 акт үйлдэж хэрэгжилтийг бүрэн хангуулсан. Зөрчлийг арилгуулахаар 1275 заалт бүхий 183 албан шаардлага гаргаж, 36.6%-ийн биелэлттэй, 1053 заалт бүхий 127 зөвлөмж гаргаж 41.7%-ийн биелэлттэй байна. Бүх нийтийн бэлэн байдал зарласантай холбоотой 1, 2-р улиралд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийгээгүй тул гүйцэтгэлийн хяналт шалгалтыг бүрэн хийх боломжгүй байлаа.

№	Хяналтын бусад хэлбэрийн ажлууд	Сэдвийн тоо		Хамруулсан объектын тоо	Гүйцэтгэлийн хувь
		Төлөвлөгөөт	Гүйцэтгэсэн		
	• Тандалт судалгаанд хамрагдсан	8	8	63	100%
	• Хяналт шинжилгээнд хамрагдсан	17	7	18	41.1%
	• Салбарын сургалт зохион байгуулсан	12	10	137	83.3%

Дүгнэлт: Хяналт шинжилгээ бүрэн гүйцэт хийгдээгүй нь бүх нийтийн бэлэн байдал, өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотой байв. 1-2-р улиралд хяналт шалгалт хийх боломжгүй коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажилд дайчлагдан ажиллаж байсан тул шинжилгээтэй хяналтын ажлууд хугацаандаа хийгдэхгүй хоцорсон. Мөн орчны эрүүл ахуйн хяналтын байцаагч түр хугацаанд жирэмсэн, амаржсаны чөлөөтэй байсан.

Хяналтын хуудасны зөрчлийн нэгтгэл:	Шалгалт	Зөвлөн туслах	Нийт
Хяналт шалгалтад хамруулсан объектын тоо	370	141	511
Илрүүлсэн зөрчлийн тоо	5061	1422	6483
- төлөвлөгөөт шалгалтаар	4993	1422	6415
- төл. бус шалгалтаар	68		68
Арилгуулсан зөрчлийн тоо	1671	340	2011

- газар дээр нь арилгуулсан зөрчлийн тоо	1012	284	1296
- гүйцэтгэлээр арилгуулсан зөрчлийн тоо	659	56	715
Арилгасан зөрчлийн хувь	33.0%	24.0%	31.0%

Дүгнэлт: Хяналтын 23 чиглэлээр 88 хяналтын хуудсаар 511 шалгалт хийж 6483 зөрчлийг илрүүлж, үүний 31%-ийг арилгуулж ажилласан. Бүх нийтийн бэлэн байдал зарласантай холбоотой 1, 2-р улиралд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийгээгүй, 3-4-р улиралд төлөвлөгөөт шалгалтыг хийсэн боловч гүйцэтгэлийн хяналт шалгалтыг бүрэн хийж зөрчил арилгахад цаг хугацааны хувьд боломжгүй байв.

Хууль сахин мөрдөлтийн түвшин:	Шалгалт	Зөвлөн туслах	Нийт
Хамрагдсан объектын тоо	446	152	598
Хууль сахин мөрдөлтийн хувь			
- төлөвлөгөөт	73.3	77.7	151
- гүйцэтгэлийн хяналт	87.2	91.7	178.9
Хууль сахин мөрдөлтийн өөрчлөлт			
- буурсан	50.0	11.0	61
- хэвэндээ	0	0	0
- нэмэгдсэн	1.0	0	1
- гүйцэтгэлийн хяналт хийгээгүй	395.0	141.0	536

Дүгнэлт: Төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн дундаж түвшин 73.3% байсан бол гүйцэтгэлийн хяналтаар 87.2% болж өссөн үзүүлэлттэй байна. Зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн дундаж түвшин өссөн байв. Цаашид шалгалтад хамрагдсан объектод хийх гүйцэтгэлийн шалгалтын тоог нэмэгдүүлэх замаар хууль сахин мөрдөлтийн түвшинг нэмэгдүүлэх боломжтой байна.

Эрсдэл үүсэх магадлал:	Шалгалт	Зөвлөн туслах	Нийт
Хамрагдсан объектын тоо	404	152	556
Эрсдэл үүсэх магадлалын хувь			
- төлөвлөгөөт	31.5	25.4	56.9
- гүйцэтгэлийн хяналт	24.7	22.8	47.5
Эрсдэлийн ангиллын өөрчлөлт			
- буурсан	51	11	52
- хэвэндээ	16	0	16
- нэмэгдсэн	0	0	0
- гүйцэтгэлийн хяналт хийгээгүй	337	141	478

Дүгнэлт: Эрсдэлийн ангиллын жагсаалтаас их, дунд үнэлэгдсэн 504 объектод төлөвлөгөөт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхэд 310 объект буюу 61.5% эрсдэлийн түвшин буурч бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Мөн төлөвлөгөөт шалгалтын эрсдэл үүсэх магадлалын дундаж хувь 29.8%, гүйцэтгэлээр 24.4% болж эрсдэлийн түвшин буурсан.

Лабораторийн шинжилгээний үзүүлэлтүүд:

№	Шинжилгээний төрөл	Шинжилсэн сорьцын тоо	Шинжилсэн үзүүлэлтийн тоо	Шаардлага хангаагүй	
				сорьцын тоо	Өмнөх онтой харьцуулахад гарсан өөрчлөлт
1	Нян судлалын шинжилгээ	488	1143	64	Эерэг сорьцын тоо 70.8%-аар буурсан.
2	Хими, хор судлалын шинжилгээ	736	2687	35	Эерэг сорьцын тоо 31.4%-аар буурсан.
3	Ургамлын үр хорио цээрийн шинжилгээ	1394	2811	66	Эерэг сорьцын тоо 1.5%-аар буурсан.
4	Нийт	2618	6641	165	Эерэг сорьцын тоо

					51.3%-аар буурсан.
Дүгнэлт:					
Энэ онд 28 нэр төрлийн 2618 дээжинд 6641 үзүүлэлтээр сорилт гүйцэтгэсэн бөгөөд үүнээс 14 нэр төрлийн 165 дээж стандартын шаардлага хангаагүй бөгөөд энэ нь нийт дээжийн 6.3% байна. Өмнөх онтой харьцуулахад дээжийн тоо 25.9%, үзүүлэлтийн тоо 37.1%, эерэг сорьцын тоо 51.3% буурсан байдалтай байна. Мөн шинжилгээнд хамрагдсан төрлөөр хяналт шалгалтын дээжийн тоо буурсан, хүсэлтийн дээжийн тоо өссөн, ЭИХХЦХХ-ээс ирүүлсэн импортын дээжийн тоо өссөн дүнтэй байна. Энэ онд 10469,9 мянган төгрөгийг дансанд төвлөрүүлсэн. Ажилчдын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхийн тулд МХЕГ, ХАБҮЛЛ болон бусад газраас зохион байгуулагдсан танхимын болон онлайн 11 сургалтад хамрагдсан. Мөн ажлын байран дахь 8 сургалт, дотоод 15 сургалтыг зохион байгуулсан.					

Хяналт шалгалтын ажлын үр дүнгийн талаарх дүгнэлт:

1. Нөхөн сэргээлт нэрийн дор хууль бус ашигт малтмал олборлох төрлийн гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр завдсан иргэд, нөхөрлөлийн үйл ажиллагааг таслан зогсоож, холбогдогчдод хариуцлага ногдуулсан бөгөөд аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд энэ төрлийн зөрчлийг бүрэн арилгасан.

2. Байгалийн нөөц баялгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах, зөрчлийг бууруулах, иргэд олон нийтийг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлыг зөрчил үйлдэгдэж болзошгүй бүс нутагт амьдарч буй иргэдэд түлхүү хийснээр иргэдийн мэдлэг хандлага өөрчлөгдөж, зөрчлийн талаарх мэдээллийг мэдээлэх эрх, үүргээ хэрэгжүүлэх хандлага нэмэгдсэн.

3. Аймгийн хэмжээнд авто зам, барилга угсралтын бүх аж ахуйн нэгжүүд бетон цутгалтын ажилд үйлдвэрийн хайрга болон бетон зуурмагыг ашиглаж хэвшсэнээр барилга байгууламжийн чанар, аюулгүй байдал дээшилсэн.

4. Коронавирусын халдвар хамгааллын дэглэм мөрдөлтийн байдалд байнгын хяналт тавьж, урьдчилан сэргийлэх шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ, сургалт мэдээллийг тогтмол хийж ажилласнаар иргэд, ААНБ-д ковидын эрсдэлээс хамгаалах эрүүл ахуйн дадал бий болж нийгэмд халдвар буурах нөхцөлийг бүрдүүлсэн.

5. 2021.03.13-ны шөнө байгалийн гамшгийн улмаас ОХУ чиглэлийн ЦДАШ унаж, баруун гурван аймгийн хэрэглэгчид 3 хоног буюу 71 цагийн хугацаанд цахилгаан эрчим хүч хязгаарлагдсан. Сүүлийн жилүүдэд эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж, ЦЭХ-ний аваарийн нөөцийг бий болгосны дүнд энэ хугацаанд сум суурин газрын барилга объект, дулааны шугам сүлжээнд хөлдөлт үүсгэхгүйгээр даван туулсан.

6. Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт шалгалтыг тогтмолжуулж, иргэдэд хүнсээ хэрхэн зөв сонгох талаар зөвлөмж мэдээллийг түгээж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн хууль стандартын мөрдөлтийн түвшинг сайжруулснаар хоол хүнснээс гаралтай хордлого халдвар гараагүй болно.

7. МХГ-ын саналаар Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт “сумдад нэгдсэн халаалтын зуух шинээр байгуулах, төвлөрсөн дулааны шугамд хэрэглэгчдийг холбох ажил”-ыг тусган хэрэгжүүлсний үр дүнд одоогоор 18 сумын 196 иргэн, ААНБ-ууд нэгдсэн дулаанд холбогдож, 290 нам даралтын зуухыг зогсоож, тухайн нам даралтын зуухнуудын түлшинд хэрэглэж байсан 8877м3 мод, 211 га талбай бүхий ой буюу 29500 ширхэг ургаа модыг жил бүр огтолж ашиглахаас хамгаалсан байна. Мөн сумдын нам даралтын зууханд гарч байсан ажилтны хөдөлмөр, нийгмийн хамгааллын эрх зөрчигдөх, техникийн болон

хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдах, халаалтын чанарын асуудлыг нэг мөр шийдвэрлэсэн.

Өргөдөл гомдол шийдвэрлэлт:

№	Үзүүлэлт	Албан бичиг	Өргөдөл гомдол	Нийт дүн	Нийт дүнд эзлэх хувь
1.	Нийт ирсэн	304	37	341	-
	Үүнээс: хариутай нь	211	37	248	72.7%
2.	Шийдвэрлэсэн нь	271	28	299	87.7%
	Үүнээс: хугацаанд нь шийдвэрлэсэн	271	28	299	87.7%
3.	Шийдвэрлэх шатандаа байгаа	33	9	42	12.3%
4.	Шийдвэрлээгүй	0	0	0	0%

Өргөдөл гомдлын агуулга:	Цаашид хэрхэн шийдвэрлэх арга зам /санал/
1. Хугацаа дууссан, чанарын шаардлага хангахгүй хүнсний бүтээгдэхүүн худалдаалж байна. 2. Цалин хөлс, нэмэгдэл, нэмэгдэл хөлс дутуу олгосон. 3. Зөвшөөрөлгүй газар эзэмшсэн, эзэмшлийн газраа тэлж хашиж авсан. 4. Хажуугийн байр болон хашаанд бусдад сөргөөр нөлөөлөх үйлдвэрлэл явуулж байна. Блок, мужаан, гутлын цех, арьс боловсруулах 5. Хог шатааж агаар, орчин бохирдуулсан	1. Тухайн аж ахуйн нэгж дотоод хяналтаа тогтмол хийж, хугацаа дууссан болон, хадгалалтын нөхцөл зөрчигдсөн бүтээгдэхүүн худалдаалахгүй. Хэрэглэгчид эрүүл хүнсний бүтээгдэхүүн сонгох мэдлэг дадалтай болох 2. Салбарын сургалт зохион байгуулж, дотоод хяналтыг сайжруулж тухайн салбарын хэмжээнд зөрчлийг нэг мөр арилгуулах. 3. Улаангом сумын Засаг даргын дэргэд газар чөлөөлөх алба бий болгож, хууль бусаар эзэмшсэн газрыг чөлөөлж, гарсан зардлыг буруутай этгээдээр төлүүлж байх. 4. Дуу чимээ, орчны бохирдол үүсгэх үйл ажиллагааг иргэдийн төвлөрөн оршин сууж буй орчноос тусгаарлан үйлдвэрлэлийн бүс тогтоож шийдвэрлэх. 5. Зөрчил гаргасан иргэдэд торгуулийн арга хэмжээ ногдуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээллэх.

Дөрөв. Хийж гүйцэтгэсэн үр дүнтэй, нийгэмд, олон нийтэд үнэлэгдсэн томоохон ажил /4-5 ажил/

1. МХЕГ-ын Эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газраас “Дижитал шилжилт ба хэрэглэгчтэй хамтарсан хяналт” сэдвийн хүрээнд IGOV.MN цахим систем, Дижитал шилжилтийн талаар сургалт мэдээлэл хийлээ. Сургалтад төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын 62 ажилтан танхимаар, 24 ажилтан онлайнаар хамрагдав.

2. “Хяналтын цаг” /подкаст/ нэвтрүүлгийн дугаарыг Эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр 1, Хүнсний чанар, стандартын хяналтын чиглэлээр 2 удаа хийж цахим орчинд түгээсэн. Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр сошиал сувгаар мэдээ мэдээлэл 46, зөвлөмж постер – 22, ТВ-ын мэдээ 13 удаа давтамжтай өгч ажилласан байна. Мөн хүнсний чиглэлийн хяналт шалгалт, коронавируст халдварын үед худалдаа үйлчилгээний байгууллагуудын халдвар хамгааллын дэглэм мөрдөлтийн талаар 3 видео мэдээлэл бэлтгэж сошиал орчинд түгээсэн.

3. “ЦАХИМ УВС” нээлттэй хаалганы өдрийн хүрээнд МХЕГ-аас хэрэгжүүлж байгаа Дижитал шилжилтийн цахим систем IGOV.MN сайтыг иргэд, ААН-үүдэд сурталчилах, иргэдийг Мэргэжлийн хяналтын байгууллагын үйлчилгээг цахимаар

авах боломжийг бүрдүүлэх хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгжүүдийг цахим системд бүртгэх зэрэг ажлуудыг зохион байгууллаа.

4. МХГ дээр байрладаг Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх шуурхай баг байгаль орчны салбарын байгууллагуудыг ахалж ажилладаг. ДБХС санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилладаг бөгөөд сүүлийн 3 жилийн хугацаанд хийсэн ажлын дүнг сайшааж баруун бүсийн хэмжээнд сайн туршлага судлах зөвлөгөөнийг зохион байгуулсан. Үүнд 4 аймгийн Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн гишүүн нийт 58 хүн аймгийн МХГ дээр ирж ажил байдалтай танилцав.

/фото зургийг хавсаргав./

Тав. Дүгнэлт

Хэвлэл мэдээллийн ажилтан ажиллуулж төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг иргэн олон нийтэд тогтмол мэдээлэлж хэвшүүлснээр нийгэмд Мэргэжлийн хяналтын байгууллагын үнэлэмж дээшилсэн.

Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд дархлаа дэмжих бүтээгдэхүүн, халдвар хамгааллын хэрэгслээр тогтмол хангаж, ажлын байран дээр эрүүл ахуйн дэглэмийг чанд мөрдөж ажилласны дүнд ажлын байран дээр коронавирусын халдвар тархаагүй болно.

Их, дунд эрсдэлтэй үнэлэгдэж хяналт шалгалтад хамрагдсан нийт объектын эрсдэлийн түвшин 61.5%-иар буурч бага эрсдэлтэй ангилалд шилжсэн. Мөн төлөвлөгөөт шалгалтын эрсдэл үүсэх магадлалын дундаж хувь 29.8%, гүйцэтгэлээр 24.4% болж эрсдэлийн түвшин буурсан үр дүн гарсан. Өмнөх онд төлөвлөгөөт шалгалтын эрсдэл үүсэх магадлалын дундаж хувь 30.3% байсан бол тайланд онд эрсдэлийн түвшинг 0.5 бууруулсан.

Зургаа. Цаашид анхаарах асуудал, санал

1. Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн өргөтгөлийн барилгын зураг, төсөв, геологийн судалгааны үнэ 30.0 сая төгрөг.
2. Мэргэжлийн хяналтын газарт хоёр автомашины граж худалдан авахад шаардлагатай 25.0-30.0 сая төгрөгийн төсвийг шийдвэрлэж өгөх шаардлагатай.
3. Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн ажиллагсдыг мэргэшлийн зэрэгтэй болгож, нэмэгдэл олгох боломжийг бүрдүүлэх.
4. Лабораторийн ажиллагсад нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлийн жагсаалт”-ын Хөдөлмөрийн хүнд нөхцөлийн ангиллын 31 дэх хэсэгт заасан ажил мэргэжлийн ангилалд хамаарч байна. Иймд тухайн ажилтнуудад хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох шийдвэрийг МХЕГ-аас яаралтай гаргах.



